



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 53

Эрдэнэт

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь хэсгийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Эрдэнэт хотын 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар ёсоор баталсугай.

2.Аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын захирагч Д.Батлутад даалгах нь:

2.1.Эрдэнэт хотын 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж ажиллуулах.

2.2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч явцыг 2017 оны 8 дугаар сард аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулах.

ДАРГА  П.ПҮРЭВЛХАГВА

